

Озон задалдаг бодисын тухай Монреалийн протоколын Тогтвортой хөгжлийн зорилгуудад оруулах хувь нэмэр



Эрүүл мэндийг дэмжих

Монреалийн протолыг хэрэгжүүлсний үр дүнд 2030 он гэхэд Дэлхий даяар жил бүр арьсны хорт хавдрын 2 сая орчим тохиолдол, нүдний болор цайх өвчний сая сая тохиолдлоос урьдчилан сэргийлнэ.



Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх

Хөгжилтэй улс орнууд нь хөгжиж буй орнуудыг Монреалийн протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь туслахын тулд 3.6 сая гаруй ам.долларын тусламж үзүүлж байна.



Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих

Монреалийн протокол нь 100-аад төрлийн озон задалдаг химийн бодисын 99%-ийг дэлхий даяар үе шаттай бууруулж, хэрэглээнээс бүрмөсөн халсан.



Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах

Монреалийн Протокол нь 1990-2010 оны хооронд 135 тэрбум тонн хэмжээтэй тэнцэх хүлэмжийн хийн ялгарлаас зайлсхийлсэн. Цаашид Кигалийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлсэнээр 2100 он гэхэд Дэлхийн дулаарлыг 0.5°C хүртэлх хэмээр багасгах төлөвтэй байна.



Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

Монреалийн протокол болон түүнийг хэрэгжүүлэхэд зориулагдсан Олон талт сан нь озоны үе давхаргыг хамгаалахын тулд хөгжиж буй 147 орны үндэсний чадавхийг бэхжүүлсэн.

БОАЖЯ-ны Озоны үндэсний алба

**Монгол улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 4, Экспресс цамхаг,
3 дугаар давхар, 304В тоот
Утас: 976 11 312458
E-mail: mongolia@ozone.mn**